

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тайлбар
Хүний нөөцийн мэдээлэлд үндэслэн нийгмийн асуудал шийдвэрлэх, дэмжин ажиллах боломжит ажилчдын тоо мэдээллийг нэгтгэн санал боловсруулж танилцуулж хэрэгжүүлэх, дүгнэлт хийж, асуудлыг шийдвэрлэх	Хүний нөөцийн мэдээлэлд үндэслэн эхний хагас жилийн байдлаар дараах дэмжлэг, туслалцааг үзүүлсэн: -Тэтгэвэрт гарсан 2 ажилтанд хамтын гэрээний дагуу нэг удаагийн тэтгэмж; -Ахуйн дэмжлэгийг 25 ажилтанд; -Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэтгэмж 10 ажилтанд; -Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 3 ажилтанд; -Хөдөлмөрийн дотоод журамд заасан цалинтай чөлөө 17 ажилтанд, цалингүй чөлөө 18 ажилтан; -Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар аавын 10 хоногийг 7 ажилтанд; - Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтны аав, ээж, ах, эгч, хүүхэд нас барсны тэтгэмжийг 18 ажилтанд; -3 ажилтанд байрны урьдчилгаа; -Нийтийн тээврийн автобусны 2 жолоочид иж бүрэн тавилгатай 5 ханатай гэр; -Нэг ажилтанд сургалтын төлбөр; -Хүүхдийн баяраар нийт ажилчдад хүүхдийн баярын бэлэг гардуулсан.
Орон гэргүй, түрээсийн орон сууцад амьдарч байгаа ажилтнуудын асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах.	Нийслэлийн Засаг Даргын захирамжаар төрийн албан хаагчдын орон байрны асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд 2025 онд 3 ажлтанд байрны урьдчилгаа олгосон.
Ажилчдаас сэтгэл ханамжийн болон ажлын орчин нөхцөлийн судалгааг авч нэгтгэж, удирдлагад тайлагнах	Нийслэлийн sudalгаа.gov.mn хаягаар судалгаа хүлээн нийтлэх ажлыг эхлүүлж байна. Мөн төрийн байгууллагын үйлчилгээний талаар судалгааг үйлчлүүлэгчдээс авч одоогийн байлаар 86 иргэдийн саналыг авсан байна.
Ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр	Байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан, дүрмийг батлуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гараагүй. Хэлтэс нэгжийн дарга нар шаардлагатай үед хэсэгчилсэн болон ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж, харилцаа, ажлын байран дахь сэтгэл ханамжийн аятай нөхцөлийг бүрдүүлсэн. 2024 оны 07 дугаар сард шинээр баригдсан оффисын барилгад нүүж орсноор ажилтан, албан хаагчдын ажлын орчин нөхцөл сайжирсан.

Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах чиглэлээр	Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 09 дүгээр сард зохион байгууллаа. 2025 оны эхний хасаг жилийн байдлаар байгууллагын эмч давхардсан тоогоор нийт 1678 ажилтанг оношилж эмчлэн, зөвлөгөө өгсөн ба үүнээс эмийн эмчилгээ-1776 ажилтанд, эмийн бус эмчилгээ дусал, судас, булчин тариа-462 хүнд тус тус үйлчилгээ үзүүлсэн байна.
Ажилчдад хууль тогтоомжийн дагуу цалин хөлс олгох	Ажилтнуудын цалинг хөдөлмөрийн дотоод журамд заасан тогтоосон хугацаанд сар бүр олгож, давхардсан тоогоор 500 гаруй ажилтанд тус тус олгосон. Сар бүр Нийгмийн даатгалын тайланг гаргаж Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газартай тооцооны үлдэгдлийг актаар баталгаажуулан ажиллаж байна.
Албан хаагчдыг сургалтад хамруулж, мэргэшүүлэх чиглэлээр	Архив, дотоод ажил хариуцсан ажилтанг Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, байгууллагын архивт баримт шилжүүлэх ажлын зохион байгуулалт” сэдэвт мэргэшүүлэх сургалтад цахим хэлбэрээр хамруулсан.